



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/600

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6./а/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 8.1.7 аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 8.1.2 дахь заалтыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, үйл ажиллагааны удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах ажилд шаардагдах 2 450 000 төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /н.Бямбацэцэгт/ зөвшөөрсүгэй.

3.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн, нэгж байгууллагуудад нийгмийн хариуцлагын талаар стандартын дагуу үнэлгээ хийх ажлыг зохион байгуулан, холбогдох байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган, тогтоосон хугацаанд гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга Ц.Баяржаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
10 дугаар сарын 12-ны өдрийн  
А/600 дугаар захирамжийн I хавсралт

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТОМООХОН  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
АЖИЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах хүн	Төсөв /төгрөг/	Хамтран ажиллах байгууллага, хамрах хүрээ
1	Үнэлгээнд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг тодорхойлох	IX/18	Ц.Баяржаргал. Г.Эрдэнэбулган Г.Баасанбилэгт		Ажлын хэсэг Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс
2	ААНБ-уудад үнэлгээ хийх тухай албан тоот хүргүүлэх,	IX/18	Г.Баасанбилэгт Г.Эрдэнэбулган Ц.Сарантуяа	20000	ААНБ-ууд
	ААНБ-уудад сургалтын зар хүргүүлэх	IX/18			ААНБ-ууд
3	“ Нийгмийн хариуцлагын удирдамж ISO 26000 ” стандартын сургалт зохион байгуулах	IX/	Г.Баасанбилэгт Л.Түмэннаст Б.Батжаргал	750000	ААНБ-ууд, Ажлын хэсэг
4	Ажлын хэсэг болон сургагч багштай уулзалт,ярилцлага зохион байгуулах	IX/		30000	Ажлын хэсэг
	Аж ахуйн нэгж, байгууллагын Нийгмийн хариуцлагын талаар хийж байгаа ажилд “ Нийгмийн хариуцлагын удирдамж ISO 26000 ” стандартын дагуу үнэлгээ хийх	X/	Ц.Баяржаргал	620000	ААНБ-ууд, Ажлын хэсэг
5	Үнэлгээний дүнг нэгтгэх, тайлан гаргах	X/30	Г.Баасанбилэгт З.Соёлмаа		Ажлын хэсэг
6	Үнэлгээний дүнд шилдэгээр шалгарсан ААНБ-уудыг туршлагыг дэлгэрүүлэх, сурталчлах	X/	Б.Батжаргал Т.Нямсүрэн Ц.Сарантуяа	600000	Ажлын хэсэг
7	Төв, орон нутгийн телевиз, вэб сайт, сонин хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах	X/	Г.Баасанбилэгт Л.Түмэннаст Б.Батжаргал	400000	ААНБ, хэвлэл мэдээллийн байгууллага
8	Үнэлгээний ажлын , тайланг Засаг даргад танилцуулах	X/10	Ц.Баяржаргал		Ажлын хэсэг
	Нийт дүн			<b>2 450 000</b>	

“ Нийгмийн хариуцлагын удирдамж /зөвлөмж/ ISO 26000 ”  
стандартын сургалтын төсөв

№	Зардалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг /
<b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b>					
1.	Дэвтэр	ширхэг	30	2000	60000
2.	Бал	ширхэг	30	800	24000
3.	Хавтас	ширхэг	30	2000	60000
<b>Цайны материал</b>					
4.	Жигнэмэг /3 төрөл /	ширхэг	90	800	72000
5.	Цай, кофе	ширхэг	90	300	27000
<b>Сургалтын зардал</b>					
6.	Багшийн хөлс	төгрөг	3 х /3 цаг /	40000	360000
7.	Сургалтын танхим	төгрөг	3цаг	30000	90000
8.	Анонс	төгрөг	5x7	8000	56000
9.	<b>Нийт дүн</b>				<b>749000</b>

“ Нийгмийн хариуцлагын удирдамж /зөвлөмж/ ISO 26000 ” стандартын  
хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний багийн үйл ажиллагааны зардал

№	Зардалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг /
1.	Бичиг цаас	боодол	3	9000	27000
2.	Үдээс	боодол	1	3000	3000
3.	Принтрийн хор	ширхэг	1	50000	50000
4.	Шатахуун	л	250	1800	450000
5.	Харилцаа холбоо	төгрөг	9	10000	90000
6.	<b>Нийт дүн</b>				<b>620000</b>